

ТАНИЛЦУУЛГА

Зарим Элчин сайд нарыг эгүүлэн татах тухай

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2020 оны 7 дугаар сарын 10-ны өдрийн 96 дугаар зарлигаар Монгол Улсаас Тайландын Хаант Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар А.Төмөрийг, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн 68 дугаар зарлигаар Монгол Улсаас Бүгд Найрамдах Ардчилсан Лаос Ард Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Ж.Бямбасүрэн нарыг тус тус томилсон.

Монгол Улсын Гадаад харилцааны сайд НҮБ-ын Ази, Номхон далайн эдийн засаг, нийгмийн комиссын 80 дугаар чуулганы даргаар 2024 оны 4 дүгээр сараас 2025 оны 4 дүгээр сарын хооронд сонгогдон ажиллах болсонтой холбоотойгоор дурдсан хугацаанд хурал, арга хэмжээнүүдийн бэлтгэлийг хангах, зохион байгуулах зэрэг ажлын зайлшгүй шаардлагын улмаас Элчин сайд А.Төмөрийн томилолтын хугацааг түр сунгасан болно. Түүнийг эгүүлэн татах асуудлаар Ерөнхийлөгчийн Тамгын газартай зөвшилцөж, 2025 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн ТГ/485 дугаартай албан бичгээр тодорхой чиглэл авсан болно.

Түүнчлэн Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 04 дүгээр сарын 09-ний өдрийн 180 дугаар тогтоолоор Засгийн газрын тохируулагч агентлаг-Хил хамгаалах ерөнхий газрын даргын албан тушаалд Элчин сайд Ж.Бямбасүрэнг томилсонтой холбогдуулан түүнийг эгүүлэн татах шийдвэрийг албан ёсоор гаргах нь зүйтэй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин гуравдугаар зүйл 1 дэх хэсгийн 5 дахь заалт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 4 дэх хэсэг, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийг тус тус үндэслэн Монгол Улсаас Тайландын Хаант Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд А.Төмөр, Монгол Улсаас Бүгд Найрамдах Ардчилсан Лаос Ард Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Ж.Бямбасүрэн нарыг эгүүлэн татах саналыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр холбогдох материалыг боловсруулав.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР